



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2015 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/38

Мэргэн хошуу

Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.21 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.17, 24 дүгээр зүйлийн 24.2, 32 дугаар зүйлийн 32.1.2 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор арилгах, хойшлуулашгүй сэргээн босгох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, эмнэлгийн болон хүмүүнлэгийн тусламж хэрэгжүүлэх зорилгоор гамшгаас хамгаалах ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийг шинэчлэн байгуулсугай.

2. Сумын хэмжээнд гамшгаас хамгаалах ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн гишүүдийн бэлэн байдлыг хангуулж ажиллахыг байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

4. Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн үйл ажиллагаанд хяналт тавьж, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 75 дугаар тушаалаар батлагдсан "Мэргэжлийн ангийн дүрэм"-ийг хэрэгжүүлж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (С.Амарболд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТБОЛД

Мэргэжлийн ангийн бүтэц

Засаг даргын 2015 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 138 дугаар захирамжийн 10 дүгээр хавсрелт

